



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 546

Бор-Өндөр сум

**Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг
Ч.Мөнгөнчимэгээр хавсран гүйцэтгүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг "Нэгдсэн эмнэлгийн дотоод журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр нэгдсэн эмнэлгийн дарга А.Батбаатар нь ажлаас чөлөөлөгдсөн тул төрийн үйлчилгээг тасралтгүй явуулах ажлын зайлшгүй шаардлагаар Бор-Өндөр нэгдсэн эмнэлгийн даргын албан тушаалд заасан шаардлагад нийцүүлэн томилох хүртэлх хугацаагаар Чогдовын Мөнгөнчимэгээр Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч Ч.Мөнгөнчимэгт ажил, эд хөрөнгө, холбогдох бичиг баримтыг хүлээлгэн өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Галбадрах

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Б.Энхмаа

Бор-Өндөр нэгдсэн эмнэлгийн Аж ахуй эрхэлсэн дарга

Гишүүн:

Ц.Эсүжин

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Ү.Алтанцэцэг

Бор-Өндөр нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн эрчимт эмчилгээний эмч


Э.Оюунболор

Бор-Өндөр нэгдсэн эмнэлгийн нярав

3. Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч Ч.Мөнгөнчимэгт Нэгдсэн эмнэлгийн даргын ажил, эд хөрөнгө, холбогдох бичиг баримтыг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хүлээлгэн өгч илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Галбадрах)-д даалгасугай.

4. Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэх хугацаанд Нэгдсэн эмнэлгийг даргын албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиар тооцож, сар бүр олгохыг Нэгдсэн эмнэлгийн санхүүд зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ